



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/472

Хэрлэн сум

Нийгмийн баталгааг хангахад  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц” хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн сумын багийн Засаг дарга нарын “Төрийн албаны тухай” хуульд заасан нийгмийн баталгааг хангахад зориулж 7,070,000 (долоон сая далан мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн шинээр батлагдсан хууль, тогтоомж шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ